

МОНГОЛЧУУДЫН ХАМТРАН АМЬДРАХ ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА

*Баатарын Наранчимэг, докторант (БНХАУ-ын Жилиний их сургууль)
МУИС-ШУС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш*

Хураангуй

Судлаач энэ ажлаараа сүүлийн жилүүдэд нийгэмд түгээмэл дэлгэрсэн гэр бүлийн хамтран амьдрах хэлбэрийн талаарх хүмүүсийн ойлголт, мэдлэгийн өнөөгийн байдалд тайлбар, дүгнэлт хийж, цаашид гэр бүлийн боловсролын чиглэлээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлсэн. Ингэхдээ ажиглалт, судалгаанд үндэслэн өөрийн үзэл бодлыг баримт, мэдээллээр нотлох, баримт мэдээлэлд задлан шинжилгээ хийх, харьцуулан тайлбарлах, нэгтгэн дүгнэх аргуудыг ашигласан. Уг бүтээлд хамтран амьдрах сонголтыг хүмүүсийн хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн шинж байдлаас хамаараад: *гэрлэлтэд бэлтгэх зорилготой хамтран амьдрах сонголт; гэрлэхээс төвөгшөөж, олны анхаарал татахгүйгээр хамтран амьдрах сонголт; туршилтын чанартай хамтран амьдрах сонголт; айл гэр болж зугаацах тоглоомын чанартай хамтран амьдрах сонголт гэсэн* ялгаатай ангилалд хуваахыг оролдсон. Мөн хамтран амьдрахыг *байж болох зүйл* хэмээн хүлээн зөвшөөрөхөд хүргэж буй ойлголт, учир шалтгааны талаар бодит үнэнтэй зөрчилдөж буй төөрөгдлүүд байгааг илрүүлсэн. Тэгээд хамтран амьдрах нь эцсийн дүндээ өөрийн хүсэл тачаалд захирагдан гэрлэлттэй холбоотой **хариуцлагаас зайлсхийхийг оролдсон, замбараагүй/ёс журамгүй** байдлыг нийгэмд халдварлуулж буй **бэлгийн амьдралын хэв маяг** болж байгааг тодорхойлсон. Түүнчлэн **орчин үеийн залуучуудын дунд гэрлэлт, гэр бүлийн үнэт зүйлсийн талаар ойлголт мэдлэг дутмаг, үнэлэмж ядуу** байгаа гэж дүгнээд гэрлэлтийн зах зээл дэх комиссын бараа гэсэн шинэ нэр томъёог гаргаж тавьсан.

Эцэст нь хамтран амьдрах хэлбэрийг илүүд үзсээр байгаа нь гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үнэлэмж, гэр бүлийн харилцааны уламжлалт нандин холбоог алдагдуулж байгаа учир залуу хойч үеийнхэнд гэрлэлт, гэр бүлийн харилцаа, түүнтэй холбогдох асуудлуудын талаар цогц ойлголт, мэдлэг өгөхөд бүхий л түвшинд анхаарч, төрөөс **гэр бүлийн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх** нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргасан.

Түлхүүр үгс: гэр бүл, гэр бүлийн хэлбэр, хамтран амьдрах, батлуулаагүй гэр бүл, гэр бүлийн боловсрол, хариуцлагагүй сонголт, замбараагүй бэлгийн харилцаа, гэрлэлтийн зах зээл, комиссын бараа

Abstract

Here author aims to provide some explanations and conclusions for public understanding and knowledge of cohabitation which became a common form of modern families. Furthermore, another aim of the research is to express own views about social needs of implementing substantial action in the field of family education. Researcher used civil registration data and secondary source of data In order to approve own views and observations. Moreover document reviews, comparing methods and summarizing techniques used for study. In this work, researcher attempted to define cohabitants' different situation in Mongolia. Cohabitation

choice of couples has been divided into following different categories by their demographic and socio-economic characteristics. Specifically, premarital cohabitation which aimed to prepare for marriage; cohabitation depend on thoughts which misgiving to marry and unwanted to draw public attention; cohabitation choice with experimental nature; and cohabitation choice with gaming nature that playing in role of spouses. Moreover, in this research found some confusions in conflict with the reality about cohabitation. That confusions related to understanding and reasons which leading to the recognition that cohabitation is an *acceptable phenomenon* in family life. Furthermore, cohabitation is ultimately determined that a *sexual lifestyle* which obeying by their sexual lust, simultaneously trying to avoid responsibility which related to marriage and infects amorality in society. In addition, its concluded that poor knowledge of concepts about marriage and family values, low standard of family life among contemporary youth, then determined new terms of the commission/second hand goods in the marriage markets.

In conclusion, at individual, institutional and national all levels need to focus on providing a comprehensive knowledge on issues related to marriage and family relations for young generations. Therefore, there made recommendations that the government should adopt and implement a National program to provide family education for public.

Key words: family, family form, cohabitation (living together), unregistered marriage, family education, irresponsible choice, dissolute sexual life, marriage market, second hand market

1. УДИРТГАЛ

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын баримт бичигт “Гэр бүл нь хүний хөгжлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, уламжлал өвлөгдөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй мөн” хэмээн тодорхойлсон байдаг. Даяарчлагдаж буй нийгэмд гэр бүлийн хэв маягт өөрчлөлтүүд орж хамтран амьдардаг гэр бүл, гэрээт гэр бүл, олон соёлт гэр бүл, улс дамнасан гэр бүл болон ижил хүйстэн гэр бүлүүд үүсэх болжээ. Дэлхийн улс орнуудын гэр бүлийн хэв маягт гарч буй эдгээр өөрчлөлтүүд нь манай улсыг ч тойрч гарсангүй. Нийгмийн ойлголт, өөрчлөлтийг хүлээн авах сэтгэл зүй, үндэсний соёл, уламжлалаас хамаараад гэр бүлийн эдгээр хэв маягууд их бага хэмжээгээр бүгд илэрч байна. Эдгээрээс Монголын гэр бүлийн харилцаанд орчин үед⁸ шинээр бий болсон ч нийгэмд “байж болох зүйл” хэмээн хүлээн зөвшөөрөгдөж ижил дасал болсон нь хамтран амьдрах хэлбэр юм.

“Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” сэдэвт 2004 ба 2009 онд давтан явагдсан судалгаагаар “Гэр бүлээ батлуулаагүй хамтран амьдрагчид гэр бүл мөн” гэдэгтэй санал нийлж буй оролцогчдын хувийн жин 28.3 хувиас 46.8 хувь болж даруй 1.7 дахин өссөн нь олон нийтийн дунд хамтран амьдрахыг гэр бүлтэй дүйцүүлэн үзэх хандлага нэмэгдсээр байгааг илтгэн харуулж байна.


Улсын хэмжээнд хамтран амьдрах хэлбэр түгээмэл болсныг албан ёсоор хүлээн зөвшөөрсний баталгаа нь 2000 болон 2010 оны тооллогоор хүн амын гэрлэлтийн байдлыг бүртгэхдээ батлуулсан гэр бүлтэй, батлуулаагүй гэр бүлтэй хэмээн тусад нь бүртгэсэн явдал болно. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого дээр үндэслэсэн “Өрх, гэр бүлийн байдал” сэдэвчилсэн судалгаанд хосууд албан ёсоор гэрлээгүй боловч

⁸ Судлаач миний бие гэрлэлт, гэр бүлийн судалгаандаа нийгмийн тогтолцооны шилжилт явагдсан 1990-ээд оноос хойши үеийг орчин үе гэж тодорхойлсон.

эхнэр, нөхөр болон хамтран амьдрах нь гэрлэлтийн нэгэн адил хүний эрхийн асуудал⁹ гэж үзээд батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүн амыг судлахдаа гэр бүлтэй хэмээн нэг ангилалд багтаасан байна.

Монгол улсын гэр бүлтэй хүн ам 2010 оны тооллогын байдлаар нийт хүн амын 60.1 хувийг эзэлж байв¹⁰. Үүнийг албан ёсны баталгаатай эсэхээр нь тусад нь салгаж тооцвол, нийт хүн амын 51.8 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 8.3 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй байв. Батлуулаагүй гэр бүлтэй хүн ам хотод хөдөөнөөс илүү байгаа нь ажиглагдсан бол нийт хүн амын хүйсийн хувьд онцын ялгаагүй байлаа (Зураг 1).

Зураг 1. Арван тав ба түүнээс дээш насны нийт хүн амд эзлэх батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүн амын хувь, байршил ба хүйсээр, 2010 он




Эх сурвалж: МУ-ын ҮСХ, Хүн ам орон сууцны 2010 оны тооллого: Үр дүнгийн хүснэгтүүдэд үндэслэн тооцсон судлаачийн тооцоолол.

Хамтран амьдрах гэр бүлийн хэлбэр нь зөвхөн залуу насныханд илэрч байгаа үзэгдэл биш юм. Насны бүлгээр нь задалж үзвэл, хамтран амьдардаг эмэгтэй хүн амын хувь 15-39 насанд эрэгтэйчүүдийнхээс өндөр, харин 39 наснаас хойш насанд хамтран амьдардаг эрэгтэй хүн амын хувь өндөр байна (Зураг 2).

⁹ ҮСХ, 2014. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2013. Нэгдсэн үр дүн.135-р хуудас.

¹⁰ МУ-ын ҮСХ, 2011 он. Хүн ам орон сууцны 2010 оны тооллого: Өрх гэр бүлийн байдал сэдэвчилсэн судалгаа, хуудас 30.

Зураг 2. Арван тав ба түүнээс дээш насны нийт хүн амд батлуулаагүй гэр бүлтэй хүн амын эзлэх хувь, насны бүлэг ба хүйсээр, 2010 он



Эх сурвалж: МУ-ын ҮСХ, 2011 он. Хүн ам орон сууцны 2010 оны тооллого: Өрх гэр бүлийн байдал сэдэвчилсэн судалгаа. Үр дүнгийн хүснэгтүүдэд үндэслэн тооцсон судлаачийн тооцоолол.

Хэдийгээр дээрх тоо мэдээллүүд нь насанд хүрэгчдийн дунд хамтран амьдрах үзэгдэл бага мэт харагдуулж байгаа ч 2010 оны хүн ам, орон сууцны тооллого явагдах тухайн нэг цаг үеийн л бодит байдлыг харуулж байгааг дурдах нь зүйтэй.

Монгол улсын хэмжээнд 1993-2013 оны хооронд гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлсэн нийт хосын мэдээллээс харахад гэрлэсэн болон гэрлэлтээ бүртгүүлсэн хугацаанууд ямар нэг байдлаар зөрүүтэй хосууд нийт бүртгүүлэгчдийн 92.9 хувийг эзэлж байлаа. Түүнчлэн тэдний 41.9 хувь нь гэрлэлтээ бүртгүүлэхээс өмнө дундаасаа төрсөн хүүхэдтэй хосууд байв¹¹. Энэ нь залуус бие биенээ сонгосон хэдий ч цаашдаа гэр бүл болж нэгдэн амьдарч чадах эсэхээ шалгахын тулд хэсэг хугацаанд хамтран амьдарч “*турилдаг*” хэв маяг манай нийгэмд түгээмэл дэлгэрээд байгаагийн нотолгоо юм.

Бид нийт насанд хүрэгчдийн хэдэн хувь нь хамтран амьдарч байгаа ерөнхий дүр төрх болон гэрлэх шийдвэр гарган гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлж буй хосуудын дунд гэрлэхээс өмнөх хамтран амьдрах үзэгдэл хэр түгээмэл байгааг л тооцож мэдэх боломж байна. Харин нийт хамтран амьдрагчдын хичнээн хувь нь албан ёсны гэр бүл болдог талаар, түүнчлэн **хамтын амьдралын түүхийг гэрлэлтийн дараалалтай нэгэн адил хүн нэг бүрийн хувьд тооцох боломж байхгүй** нь маргаангүй үнэн. Учир нь хамтран амьдрагчид хууль ёсны бүртгэлгүй байдаг тул тэдний хувьд салалтын бүртгэл ч байхгүй, хэн ч үүнийг хянаж, илрүүлж чадахгүй гэсэн үг. Тиймд судлаач миний дүгнэж байгаагаар хамтран амьдрах гэр бүлийн хэлбэр нь илрүүлэн судлахад төвөгтэй, гэр бүлийн харилцааны хөгжилд замбараагүй байдлыг бий болгогч, нийгэмд бодитоор илрэх сөрөг үр дагавруудыг нь бид харж, халагласаар байгаа бөгөөд нийгэмд хүлээн зөвшөөрч боломгүй үзэгдэл юм.

¹¹ Хуучнаар УБЕГ-ын гэрлэлтийн бүртгэлийн 1993-2013 оны задгай мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоолол.

Гэр бүлийн шинэ хэлбэрүүдийн талаар эрдэмтэн судлаачид өөр өөрсдийн байр суурийг илэрхийлсэн байдаг. Зарим судлаачид хөгжлийг даган илэрсэн байж болох үзэгдэл мэт хүлээн зөвшөөрдөг бол заримынх нь хувьд гэр бүлийн үнэ цэнийг алдагдуулж, хөгжилд тушаа болж буй үзэгдэл хэмээн тодорхойлж байгаа юм. Тухайлбал, “Гал голомт” Үндэсний хөдөлгөөний тэргүүн, Зууны шилдэг улстөрч эмэгтэй Д.Мөнхөө гэр бүлийн асуудлаарх нэгэн ярилцлагад: “...**Үндэсний аюулгүй байдлын гол зогцоо нь гэр бүлийн бэхжилт, хөгжлийн асуудал мөн. Монголын гэр бүлийн асуудал хамгийн төвөгтэй асуудал болоод байгаа гэдгийг нийгэмд хэлэх ёстой. Учир нь гэр бүлтэй холбоотой асуудлууд нийгмийн тогтвортой байдал ба хөгжлийг чөдөрлөж байгаа маш том хүчин зүйл юм**¹²” гэж дурджээ. Түүнчлэн өнөөгийн нийгэмд орчин үеийн гэр бүлийн өвөрмөц, шинэ хэв маягууд олшрох тусам **гэр бүл гэх ойлголт бүдгэрч, бүр үгүй болох** магадлал буйг гэр бүл судлаач Т.Намжил онцлон тэмдэглэж байсан. Тэрээр “...**социализмын гавьяа бол хос гэр бүлийг бий болгож, бусад хэв маягийг хорьсон. Хэрэв социализмын үед задарсан бол өнөөдөр бүр замбараагүй байх байсан**” хэмээн уламжлалт хэв маягийг илүүд үздэгээ илэрхийлсэн¹³.

Эндээс гэр бүлийн амьдралын хэв маягт шинээр хүч түрэн орж ирсэн **хамтран амьдрах** хэлбэр нь хүмүүсийн сэтгэл зүйд янз бүрээр тусч байгаа бөгөөд хэдийгээр ил гаргаж зүрхлэхгүй, ямар нэгэн баримтыг хөндөхгүй байгаа ч энэ сэдэв нь олон монголчуудын хувьд маш “эмзэг” зүйл болон хувирч байгааг¹⁴ цохон тэмдэглэх нь зүйтэй. Тиймд “**Даравч дардайна, булавч бултайна**” гэдэг үгээр энэ тухай хөндөж, нийгэмд болон олон нийтэд зөв талаас нь ойлгуулж, ямар нэгэн гарц олох зайлшгүй шаардлага нэгэнт бий болж байгаа нь үнэн.

Түүнчлэн гэрлэлт, гэр бүл судлалын чиглэлээр хийгдэж буй ажлууд, судалгаа шинжилгээний бүтээлүүдээс харахад гэр бүлд тулгамдаж буй эдийн засаг, нийгэм, гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжил, хүчирхийлэл, эрх зүй, ёс суртахууны талууд дээр ихэвчлэн анхаарал хандуулсан байдаг. Гэтэл гэр бүл хэмээх бичил орчныг үүсгэх нөхцөл болж буй **гэрлэлт, түүний хэв маягийг тусгайлан судалсан судалгаа дутагдалтай** байгаа юм. Өөрөөр хэлбэл, залуучуудын гэр бүлийн боловсрол хэр зэрэг эсэх, хамтран амьдрах хэлбэрийг сонгосноор гэр бүлтэй холбоотой тулгамдсан асуудлуудыг үнэхээр шийдэж чадаж байгаа эсэх, хамтран амьдарснаар гэрлэх суурь нөхцлийг бүрдүүлж чадаж байгаа эсэх, хамтран амьдрах хандлага их байгаа ч тархалт нь яг ямар түвшинд байгаа, хамтран амьдрагсад тулгамдаж буй асуудлууд, хамтран амьдарснаар нийгэмд ямар нөлөө, үр дагаврууд бий болж байгаа зэрэг асуултууд хариулт нь тодорхойгүй бүрхэг хэвээр байсаар байна.

2. ҮНДСЭН ХЭСЭГ

Судлаач миний бие энэ ажлаар гэр бүлийн хамтран амьдрах хэлбэрийн талаарх хүмүүсийн ойлголт, мэдлэгийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид гэр бүлийн

¹² Л.Цэдэвсүрэн, 2011 он. Гал голомт Үндэсний хөдөлгөөний тэргүүн Д.Мөнхөөтэй хийсэн ярилцлага. <http://miss.mn/2369.html>

¹³ В.Батцэцэг, 2013 он. *Монгол гэр бүл*. Цуврал – 2. Нийтлэл. <http://www.shuud.mn/content/read/292677.htm> хуудсанд 2013 оны 10 сарын 21-нд нийтлэгдсэн.

¹⁴ Г.Галбадрах, 2011 он. *Гэр бүлийн үнэт зүйлс ба хамтран амьдрагсад*, нийтлэл. <http://www.orloo.info/writers/galbadrah/6152-2011-01-04-17-20-02>

боловсролын чиглэлээр макро, микро түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх өөрийн үзэл бодлыг илэрхийлэхийг зорьлоо.

Хамтран амьдрагчид жинхэнэ гэр бүл мөн үү?

Хууль эрх зүйн талаасаа хамтран амьдрах нь гэр бүлийн хэлбэрт тооцогдож чадахгүй. “Гэр бүлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу төрийн бүртгэлийн байгууллагад албан ёсоор бүртгүүлж, хоёр талын эрх, үүргийн харилцаа үүссэн хамтын амьдралыг л гэрлэлт, гэр бүл хэмээх ойлголтын хүрээнд авч үздэг. Нөгөө талаас дундын өмч үүсгэх, баялаг бий болгох, орон байртай болох, санхүүгийн дэмжлэгийн олон төрлийн үйлчилгээ авахыг хүссэн тохиолдолд хууль эрх зүйн талаасаа албан ёсны эрх, үүргийн харилцаа үүсдэггүй учраас хамтран амьдрагчид жинхэнэ утгаараа гэр бүл болж чаддаггүй.

Гэрлэх эсвэл хамтран амьдрах сонголт

Гэрлэх нь хоёр хүний хувийн хэрэг мэт боловч цаанаа утга учир үр нөлөө ихтэй, нийгмийн чухал үзэгдэл мөн¹⁵. Германы гүн ухаантан А. Шопснгауэр (1788-1860) нэг зохиолдоо “Гэрлэнэ гэдэг бол өөрийн эрхийг хоёр дахин багасгаж, үүргээ хоёр дахин ихэсгэнэ гэсэн үг”¹⁶ хэмээн бичсэн нь гэрлэлт үүрэг хариуцлагатай салшгүй холбоотойг сануулж буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл, В.А.Сухомлинскийн хэлснээр¹⁷ “Хэрвээ та хар амиа бодсон бэртээгчин бол гэр бүл байгуулах эрхгүй”. Түүнчлэн Б.Бор өөрийн зохиолдоо¹⁸ залуучуудад хандан “Гэр бүлийн эдийн засгийн үндэс, суурь байж гэмээнэ гэрлэвэл сайн. Гэхдээ эдийн засгийн үндэстэй байгаа нь энэ гээд эд хөрөнгөтэй гэрлэхивэл муухай” гэж бичсэн байдаг.

Тиймд залуучууд гэрлэх шийдвэр гаргахын тулд бие махбод, оюун санаа, зан чанар, үзэл бодлын хувьд **төлөвшсөн**, гэрлэлтийг даган ирэх үүрэг, хариуцлагыг хүлээхүйц **чадвартай** болсон байх нь чухал.

Орчин үед залуучууд хайр сэтгэлээрээ гэрлэхээс гадна харилцан ашигтай байхаар үнэт зүйлсийн солилцоо хийх (Ж.Хоманс, Г.Веккер), хэрэгцээгээ харилцан нөхөх (Р.Уинч) үүднээс ханиа сонгодог болжээ. Залуучуудын ханиа сонгох чөлөөт сонголтод хайр сэтгэл, зан чанар, ёс суртахуун, халамж анхаарал, мэдлэг чадвар, боловсрол, орлого хөрөнгө чинээ, нэр хүнд, байр суурь, удам угсаа, нас гэх мэт олон шалгуур тавигдаж байна¹⁹.

Гэрлэлтээ албан ёсоор баталгаажуулсан гэр бүлүүдийн дунд үл ойлголцол, үзэл бодлын зөрчилдөөн, эрх ашгийн сонирхол, гэр бүлийн хүчирхийлэл, итгэл алдрах зэрэг янз бүрийн асуудлуудаа шийдвэрлэж чадаагүйн улмаас тусдаа амьдрах, гэрлэлтээ цуцлуулах үзэгдэл цөөнгүй байгаа юм. Ийм тохиолдолд гэр бүл цуцлуулахтай холбоотой эд хөрөнгө хуваах, үр хүүхдийнхээ асран халамжлагчийг тодорхойлох, хүүхдийн тэтгэмж тогтоолгох гэх мэт шийдвэрлэвэл зохих ярвигтай асуудлууд давхар тулгардаг. Тиймээс

¹⁵ Б.Бор, 1988 он. *Гэрлэлт, гэр бүлийн тухай залуучуудад өгүүлэх нь*. Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар. Хуудас 6.

¹⁶ Б.Бор, 1988 он. Хуудас 8.

¹⁷ Б.Бор, 1988 он. Хуудас 24.

¹⁸ Б.Бор, 1988 он. Хуудас 25-26.

¹⁹ Шинжлэх ухааны академи, Философи социологи эрх зүйн хүрээлэн, 2012. Монголын залуучуудын нийгмийн дүр төрх: XX-XXI зууны зааг үе, хуудас 96-98.

залуучууд ямар нэгэн төвөгтэй асуудалд орохгүй байх үүднээс “хамтран амьдарч үзэх нь дээр” гэсэн сонголтыг хийх болсон.

Залуучуудын гэр бүл, гэрлэлтэд хандах хандлага, хамтран амьдрах хэлбэрийн талаарх тэдний байр суурь ямар байгааг тодорхойлох үүднээс хийсэн нэгэн судалгааны үр дүнд дараах сонирхолтой үр дүн гарчээ. Судалгаагаар Монголд шинээр танилцсан 100 хос тутмын 50 нь цааш гэр бүл болж аз жаргалтай амьдардаг, харин гэр бүл болсон хосын 60 хувь нь гэрлэхээсээ өмнө хамтран амьдардаг гэсэн байна. Түүнчлэн залуус гэр бүлээ батлуулах сонирхолтой байдаг ч гэрлэсний дараах үүрэг хариуцлагаас зугтах боломжийг илүүд үзэх болсныг дурджээ. Тодруулбал, таны бодлоор хосууд ямар шалтгаанаар хамтран амьдрах хэлбэрийг сонгодог бол? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 30 хувь нь бие биенээ таньж мэдэх, эхнэр нөхрөө шинжих зорилгоор гэж хариулсан байхад 30 орчим хувь нь хариуцлагаас зайлсхийх, 25 хувь нь гэр бүл болоход бэлэн бус гэж хариулсан бол салахад амар, гэрлэлтийн талаар буруу ойлголттойгоос гэсэн хариултыг 10 гаруй хувь нь өгчээ. Түүнээс гадна, таны эргэн тойронд хамтран амьдрагч байгаа юу? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 65.7 хувь нь тийм гэдэг хариултыг өгсөн байснаас гадна хамтран амьдрах үзэгдэл цаашдаа улам л нэмэгдэнэ гэж үзсэн байна²⁰.

Хамтран амьдрах сонголтыг хүмүүсийн хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн шинж байдлаас хамаараад харилцан ялгаатай бүлгүүдэд хувааж болох юм . Үүнд:

- *Гэрлэлтэд бэлтгэх зорилготой хамтран амьдрах сонголт:* Өмнө нь залуу хосууд танилцаж, тодорхой хугацаанд болзож үзээд улмаар гэрлэх шийдвэр гаргадаг байсан бол орчин үед гэрлэлтийн өмнөх үе шатуудад туршилтын хугацаанд хамтран амьдрах гэсэн үе шат нэмэгдэх болжээ. Энэ үе шатыг туулж өнгөрүүлэх тал дээр байр сууриа илэрхийлэгчдийн хувьд “Хүний сайныг ханилан байж, хүлгийн сайныг унан байж мэддэг” гэсэн ардын сайхан зүйр үгийг бамбайгаа болгодог. Ийм төрлийн хамтран амьдрагчдын хувьд сонгосон хостойгоо яваандаа гэрлэнэ гэсэн хүлээлттэй байдаг.
- *Гэрлэхээс төвөгшөөж, олны анхаарал татахгүйгээр хамтран амьдрах сонголт:* Анхны амьдрал нь гэр бүл цуцлалтаар төгссөн эсвэл бэлбэсэн хүмүүсийн хувьд хоёр дахь, гурав дахь амьдралаа зохиохдоо хууль ёсны гэрлэлтэд ач холбогдол өгөхгүй байх, дутууг гүйцээж, дундуураа дүүргэх хань ижилтэй байвал болоо гэсэн хандлагаар хамтран амьдрахыг илүүд үзэх тохиолдол цөөнгүй байна.
- *Түр орлуулах чанартай хамтран амьдрах сонголт:* Олон жил гадаад оронд мөнгөний төлөө ажиллаж амьдарч байгаа зарим хүмүүст зайлшгүй шаардагдаж буй физиологийн хэрэгцээ, ажлаас ядарч ирэхэд нь үгүйлэгдэж байгаа халамж анхаарал, сэтгэл санаа болоод зовлон жаргалаа хуваалцах гэсэн оюун санааны хэрэгцээ, түүнчлэн өртөг өндөртэй газар ажиллаж амьдрахдаа өмнөө тавьсан зорилгоо биелүүлэхийн тулд зардлаа хэмнэхийн тулд хоорондоо тохиролцон хамтран амьдрах үзэгдэл нэлээд бий.
- *Туршилтын чанартай хамтран амьдрах сонголт:* Хамтран амьдрагчтайгаа тодорхой хугацааны дараа гэрлэнэ гэсэн итгэл анхнаасаа тээгээгүй боловч бие

²⁰ Ш.Оюундалай, 2008 он. Өнөөдөр сонин. *Хамтран амьдрагчид гэр бүл мөн үү?* нийтлэл. <http://news.gogo.mn/r/19069> цахим хуудсанд 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдөр нийтлэгдсэн.

физиологи, оюун санаа, эдийн засгийн болон бусад хэрэгцээгээ харилцан хангаж хамтдаа амьдарч буй хосууд бас байдаг. Тэд насаар тийм ч залуу биш, ойр дотныхных нь зүгээс үе үе хүнтэй суух нас оройтож болзошгүй талаар ямар нэг байдлаар сануулж байдаг хүмүүс байх магадлалтай. Тэдний хувьд энэ төрлийн хамтран амьдрах сонголт нь өөрт шаардлагатай хэрэгцээгээ нөхсөн эрх чөлөөт харилцааг ганцаар амьдрахаас илүүд үзэх хандлагаар илэрч байгаа юм. Тэд битүүхэндээ хамтран амьдарч буй хосоо хүнийх нь хувьд таньж, цаашдаа итгэл даагаад амьдарч чадах эсэх талаар бие биеэ туршсан, тандсан байдалтай байдаг ч ямар нэгэн асуудлаас болж хамтын амьдралаа үргэлжлүүлэхээ больсон тохиолдолд сэтгэл зүйн хувьд салалтад бэлтгэлтэй байдаг.

- *Айл гэр болж зугаацах тоглоомын чанартай хамтран амьдрах сонголт*: Үндсэн гэрээсээ буюу эцэг эх, асран халамжлагчийнхаа хараа хяналтаас хол өөр аймаг, хотод эсвэл хилийн чанадад суралцаж, бие даан ажиллаж амьдарч буй цэцэг цэврүү шиг 18-25 насны залуучуудын дунд гэрлэх эцсийн зорилгогүйгээр хамтран амьдрах, ойр ойрхон хамтрагчаа солих сонирхол, тохиолдлууд харьцангуй илүү ажиглагддаг. Тэдний хувьд харилцан үүрэг хүлээхгүй, физиологийн болоод бусад хэрэгцээгээ нөхсөн эрх чөлөөт харилцаатай. Цаг нь ирэхэд салаад явахад бэлэн байдгаараа онцлогтой.

Гэрлэлт ба хариуцлагатай амьдрал

Гэр бүлийг судлах нийгэм, сэтгэл зүйн урсгалыг үндэслэгч Эрнст Бержер (1886-1966 он) гэр бүлийн харилцааны асуудлаарх судалгаандаа “*Гэр бүл зарим үүргүүдээ гээгээд зогсохгүй бүтэц, үйл ажиллагаа нь өөрчлөгдөж байна*” гэжээ²¹. Хосууд хамтран амьдарснаар гэрлэлтээс үүдэлтэй үүрэг, хариуцлагаас зайлсхийж байгаа төдийгүй ямар нэгэн асуудал гарахад гэр бүлээ хамгаалж үлдэх тал дээр олонх нь ямар нэг шийдвэртэй алхам хийхээс хойш суудаг байна.

Хамтран амьдрагчдын хувьд хүүхэдтэй болох тохиолдол цөөнгүй байдаг. Нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн эмгэг асуудалгүй хүмүүсийн хувьд хүүхэдтэй болох амархан ч хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх эцэг, эх байх нь амаргүй үүрэг, хариуцлага юм. “Гэр бүл анхаарлын төвд” байгууллагынхны тодорхойлсноор “*Эцэг, эх байх нь галзуу хулганаар давхих мэт*” гэжээ. Энэ нь галзуу хулгана тоглоомонд нэгэнт суусан бол дундаас нь бууна гэсэн ойлголт байхгүй, тоглоом дуусаж, машин зогсох хүртэл хичнээн хэцүү, аймшигтай эсвэл сайхан санагдсан ч эцсээ хүртэл явах хэрэгтэй болдог тухай санааг илэрхийлсэн.

Зарим хүмүүс эцэг, эх байхаас татгалзаж хүүхдээ бусдад өргүүлэх, асуудлаас зугтан хамтын амьдралыг орхиж, эцэс болгох тохиолдол гардаг ч энэ нь асуудлыг шийдвэрлэсэн гэсэн үг биш. Магадгүй галзуу хулганаас ямар нэг арга замаар буусан байж болох ч сайхан газардахгүй нь тодорхой. Учир нь хүүхэдтэйгээ мах, цус, сэтгэл зүй, хувь тавилангаараа нэгэнт холбогдсон байдаг.

“Гарын таван хуруу” Монголын уран сайхны киноны Шагдарын дүрээр гэр бүлийн асуудлууд, хариуцлагаас зайлсхийж, галзуу хулганаас сайн дураараа буухыг оролдсон үйлдлийг төлөөлүүлэн жишиж болох юм. Гэр бүлээс гадуурх харилцаа үүсгэн, гэр бүлээ орхиж явахаар шийдсэн Шагдарт эхнэрийнх нь хэлсэн сүүлчийн үг болох “*Чи ингэж ярьж*

²¹ Т.Намжил, 2015. *Монгол гэр бүл*, Хүүдас 41.

байхаар бид нарыг хайрлах талаар бодож болсонгүй юу?” хэмээсэн асуултад хамтдаа үүрэх үүрэг, хариуцлагыг сануулсан далд утга санаа шингэсэн байдаг. Шагдарын хувьд асуудлаас зайлсхийж, өөрийн аз жаргалыг олсон мэт боловч орхиод явсан хүүхдүүдтэйгээ харилцах харилцаанаас нь сэтгэл зүйн хувьд галзуу хулганаар давхисан хэвээр байгаа нь харагддаг. Тэр асуудлыг шийдвэрлээгүй, харин ч бүр төвөгтэй байдалд шилжүүлсэн юм.

Хүүхэд бол хүний амьдралдаа үүрэх учиртай хамгийн том үүрэг, хариуцлага мөн. Тэд өөрсдийн хүсэлтээр биш, эцэг эхийн хийсэн сонголт, үйлдлийн үр дүнд энэ хорвоод мэндэлдэг. Хосууд албан ёсны баталгаатай гэр бүл үү, баталгаагүй хамтран амьдрагчид уу гэдгээс үл хамааран нэгэнт төрсөн хүүхдийнхээ өмнө хариуцлага үүрэх нь зүйд нийцнэ. Харин ийм хариуцлагатай том үүрэгтэй урсгалаараа явж байгаад гэнэт нүүр тулах биш, урьдчилж төлөвлөөд, бүх талаар бэлэн гэж үзсэн үедээ хүсэн хүлээх нь галзуу хулганаар аялах аялалаа амжилттай төгсгөхийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Төөрөгдөл ба үнэн

Өндөг хагарч, өсөж томрон үүрээ орхин нисдэгчлэн үр хүүхэд бүр цаг нь болоход өрх тусгаарлан өөрсдийн амьдралыг зохиодог нь жам юм. Мэдээж хүн бүр сайн сайхан амьдралыг хүсэн мөрөөдөж, эцэг эх бүр үр хүүхдүүдээ алдаж, бүдрэхээс хамгаалахыг хүсдэгийг үгүйсгэх хүн байхгүй гэхэд хилсдэхгүй. Хэдий тийм боловч гэрлэлт, гэр бүлийн талаарх ойлголт, мэдлэг, үзэл бодлоосоо хамаараад харилцан адилгүй сонголт хийж байдаг.

Бидний амьдралд өрнөж буй бүх зүйлд учир шалтгаан байдгийн нэгэн адил ямар нэг шалтгаан, үндэслэлтэйгээр хүмүүс хамтран амьдрахыг *байж болох зүйл* хэмээн хүлээн зөвшөөрдөг буй за.

Судлаач миний бие хамтран амьдрахтай холбоотой олон нийтэд байдаг зарим эндүү ташаа ойлголтыг өөрийн ажиглалт, судалгаа, үзэл бодлын үүднээс тайлбарлах гэж оролдлоо.

- **Төөрөгдөл 1:** Хамтран амьдарснаар гэрлэлтийн талаар алдаатай шийдвэр гаргахаас зайлсхийж чадна гэж боддог.

Гэрлэлтийг энгийнээр тодорхойлбол насан туршийн харилцаандаа хөрөнгө оруулах шийдвэр юм. Гэрлэж буй хосууд бие биедээ амлалтыг өгдөг бөгөөд амлалтаа биелүүлэх хамтын аялалаа эхлүүлдэг.

Уншигч авхай танд хамтран амьдарснаар гэрлэлтийн талаар **алдаатай шийдвэр гаргахаас зайлсхийж чадахгүй** гэж хэлмээр байна. Үнэндээ хамтран амьдрах шийдвэр нь өөрөө **гэрлэлтийн үнэ цэнийг алдагдуулаад зогсохгүй, дараа дараагийн алдаатай шийдвэрүүдийн үүд хаалгыг нээж, сөрөг үр дагавруудыг бий болгож байдаг**. Тодруулбал, хүсээгүй жирэмслэлтээс үүдэлтэй үр хөндөлт²², хүсээгүй хүүхэд ба аргагүй байдалд орсон гэрлэлт²³,

²² УСХ, 2014. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС), 2013. Нэгдсэн үр дүн. Хуудас 253.

²³ 1993-2013 оны хооронд гэрлэлтээ батлуулсан хосуудын бараг тал хувь нь гэрлэхээс өмнө дундаасаа хүүхэдтэй гэсэн бүртгэлийн мэдээлэл байгааг дээр дурдсан. Тэдний дунд хүүхэдтэй болсон учраас гэрлэлтээ батлуулсан хосууд байгааг үгүйсгэхгүй.

албан ёсны бус харилцаа ба гэр бүлийн тогтворгүй байдал, хөндлөнгийн оролцогч талуудын оролцоо (эцэг, эх, хамаатнууд болон бусад), үл итгэлцэл ба үнэнч бус байдал, тодорхойгүй байдал ба хүлээх цаг хугацаа, дундын өмчийн харилцаа хууль эрх зүйн талаас үүсдэггүй учир эдийн засгийн хөрөнгө оруулалтын үр ашиггүй зарцуулалт, сэтгэлийн шарх, таагүй дурсамж гэх мэт.

Манай Монголчууд шиг хэдэн үеэрээ хамтдаа нийлмэл өрх үүсгэн амьдардаг онцлогтой ард түмний хувьд цаашдаа гэр бүл болж сайхан амьдарна гэсэн итгэлээр хамтран амьдарч буй хосуудын амьдралд хөндлөнгийн оролцогч талуудын оролцоог энд нэлээд чухлаар тодотгох нь зүйтэй. Учир нь албан ёсных биш учраас энэхүү харилцаа хамгаалалтгүй, таслахад хялбар байдаг. Эцэг, эхчүүдийн хувьд үр хүүхдийнхээ сонголтыг урьдаас тааж, шууд буруутган эсэргүүцэж, таслан зогсоож чадахгүй байгаа тохиолдолд хамтран амьдрах явцад нь таарч тохирохгүй, болж бүтэхгүй болбол салахад асуудалгүй гэж үзэх нь бий. Энэ тохиолдолд үр хүүхдийнхээ хувийн амьдралыг тусдаа гэж тооцохгүйгээр өөрсдийн хийж буй үйлдэлдээ шийдвэр гаргах эрх мэдлийг нь 100 хувь шилжүүлж өгөхгүй, хөндлөнгөөс оролцох хандлага түгээмэл байдаг. Энэ талаар зохиолч Жу Хён Сам “Гэрлэлтийн заавар” номондоо²⁴ “Эр хүн эцэг, эхээ орхин эхнэртэйгээ нийлж, хоёул нэг махбод болно” хэмээсэн нь цаагуураа өөрсдийн гэсэн тусдаа амьдралыг зохиож, түүнтэй холбогдох бүхий л асуудалд шийдвэр гаргах эрх мэдлийг эцэг, эхийн зүгээс хүүхдүүддээ шилжүүлж өгөх, ингэснээр хүүхдүүдийнхээ амьдралд хөндлөнгөөс оролцохгүй байх нь бат бэх гэр бүлийн үндэс болно гэж тайлбарласан байна. Үүнийг Т.Парсонс (1902-1979 он) “Төрөл садангийн зүгээс тавих хяналт сулрах явцад гэр бүл улам бүр биеэ дааж эхэлдэг”²⁵ гэж дүгнэн хэлсэн байдаг. Мэдээж энэ мэт хяналт, оролцоог таслан зогсоох, зохицуулах явдал нь гэрлэлт албан ёсных болж гэмээнэ бүрэн утгаараа хэрэгжих юм.

Хамтран амьдрагчтай эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ЖСАХ-ийн талаарх мэдлэг (98.3-99.6 хувь) маш өндөр боловч хэрэглээ хангалтгүй байгаа нь судалгаагаар батлагдсан²⁶. ЖСАХ-ын хангагдаагүй хэрэгцээ, хэрэглэх дадал хэвшээгүй байдлаас үүдсэн хүсээгүй жирэмслэлтийг үр хөндөлтөөр төгсгөх нь залуу охид, эмэгтэйчүүдийн дунд элбэг байна. Үр хөндүүлэх нь охид, бүсгүйчүүдийн сэтгэл зүй, нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, дахин үрийн зулай үнэрлэх боломжгүйд хүргэх, цаашилбал амь насаа алдах эрсдлийг дагуулдаг хор уршигтай үйлдэл юм. Харин хүсээгүй жирэмслэлтээ төрөлтөөр төгсгөснөөр дээрх хор уршгаас сэргийлэх сайн талтай ч төлөвлөөгүй олон асуудалтай нүүр тулж, даван туулах нөхцөл байдалд оруулдаг.

Дээрх сөрөг үр дагавруудыг гаргахгүй байх талаас нь зохицуулаад байх боломжтой учир хамтран амьдрах нь гэрлэлтэнд бэлтгэх хамгийн оновчтой арга мөн гэсэн байр суурьтай хүмүүс байж болох юм. Гэвч сэтгэл судлаачдын үзэж буйгаар хамтран амьдраад 3 жил болоход албан ёсоор гэрлээгүй хосууд хойшид ч ийм алхам хийхээс бэргэдэг, зайлсхийдэг гэдгийг мэдэхэд илүүдэхгүй. Хамтран амьдрах сонголт нь нэг талаасаа албан ёсны гэрлэлтээ баталгаажуулах тэр

²⁴ Жу Хён Сам, 2014 он. Гэрлэлтийн заавар, орчуулгын ном.

²⁵ Т.Намжил, 2015. Монгол гэр бүл, 36-р хуудас.

²⁶ ҮСХ, 2014. НҮТС, 2013. Хуудас 218-220, 253.

цагийг хүлээх үе байдаг. Хүлээлт нь хугацааны хувьд тодорхойгүй байх тусмаа хэцүү даваа болж байдаг бол цаг хугацаа гэдэг зүйл тасралтгүй үргэлжилж, цагийн аясаар залуу нас, гоо сайхан, эргэн тойрны юмс бүгд өөрчлөгдөн хувирч байдаг нь жам ёсны үзэгдэл юм.

Хосууд гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлэх нь үнэндээ улсын хамгаалалтад орлоо л гэсэн үг. Энэ нь цаашдаа гэр бүлийн хуульд заагдсан эрх, үүргүүдийг эдлэх бүрэн боломж олгохоос гадна гэр бүл бат тогтвортой байх үндэс болно²⁷.

Тиймд гэр бүлийн амьдралын их далайд хөл тавих гэж буй хэн бүхэн өөрийн завийг эрсдэлтэй нөхцөлд чиглэлээ буруу тодорхойлон жолоодож явах сонголт хийснээс оройтсон ч хамаагүй бүх бэлтгэлээ базааж, бэлэн болсон цагтаа далайд гарсан нь дээр. Хамтран амьдрах сонголт хийхээсээ өмнө “*Эх нь булингартай бол адаг нь булингартай*” гэсэн ардынхаа сайхан зүйр үгийг санаж явахад илүүдэхгүй.

- **Төөрөгдөл 2:** Хурим найр хийхгүй, боломжгүй юм чинь хамтран амьдраад явж байя.

Гэрлэх шийдвэр нь гэр бүл гэдгээ хуулийн этгээдэд албан ёсоор бүртгүүлж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно. Хуримын ёслол хийх нь гэрлэлтээ батлуулахаас тусдаа асуудал юм. Тийм ч утгаараа гэрлэх ёслолын ордонд гэрлэлтийн баталгаа хийдэггүй. Гэрлэлтийг харьяа орон нутгийн захиргааны байгууллагын иргэний бүртгэлийн албанд бүртгүүлснээр хуулийн дагуу албан ёсных болдог.

- **Төөрөгдөл 3:** Дундаас дээш насны (ганц бие, салсан, бэлбэсэн) хүмүүсийн хувьд анх удаа/дахин гэрлэж буйгаа албан ёсоор бүртгүүлэхгүйгээр харилцан хоёр биедээ түшиг тулгуур болж, хамтран амьдрах нь бусдад хүртээлгүй, зөвхөн тэдний өөрсдийн шийдэх хэрэг гэж боддог.

Бидний үр хүүхэд эцэг, эх, насанд хүрэгчид бидний хэлэх үг ярианаас илүү хийж буй үйлдэл, аливаад хандах хандлагаас суралцаж, амьдралын тухай ойлголт, мэдлэг олж аван, даган дууридаг. Тиймд хамтран амьдрахыг илүүд үзсэн ийм төөрөгдөл, хандлага нийгэмд түгээмэл тархах нь ирээдүй, хойч үеийнхэнд гэр бүлийн үнэт зүйл алдагдаж, гэрлэлтийн үнэ цэнийг доройтуулсан ойлголт, хандлагыг өвлүүлэн үлдээх аюултай.

- **Төөрөгдөл 4:** Хамтран амьдрах нь хэсэг хугацаанд физиологи, эдийн засгийн болон бусад хэрэгцээгээ хангах арга зам гэж боддог.

Шуудхан хэлэхэд хамтран амьдрах нь бэлгийн харилцааны хамтрагчтай болох гэсэнтэй агаар нэгэн ойлголт.

Хувь хүн нь оюун ухаантай, бие бялдартай, сэтгэл хөдлөлтэй, ёс зүйтэй, нийгмийн амьтан. Хувь хүнийг энэ салбар бүрээр нь салангид ойлгох бус, нэгэн

²⁷ Б.Бор, 1988 он. Хуудас 41-42.

цул бодгаль гэдгээр нь авч үзэх хэрэгтэй. Бэлгийн харилцаа нь дан ганц бие махбодын үйл биш гэдгийг ухамсарлан, ойлговол зохино²⁸.

Бэлгийн харилцааны үед бэлгийн замаар дамжих олон төрлийн халдварууд авах болон жирэмслэх эрсдэлтэй байдгийг хүн бүр мэддэг ч, үүнтэй адил зарчмаар удмын сангийн мэдээлэл нь харилцан солилцож байдгийг тэр бүр мэдэхгүй байж болох юм. Тиймд түр хугацаанд хамтран амьдарч, бэлгийн харилцаанд орсноор насан туршдаа нөгөө хүнийхээ генийн мэдээллийг тээж явах болдог. Бэлгийн замаар дамжих халдвар торон хэлхээс үүсгэн хэдэн хавьтагчтай байхаас үл хамааран тархдагийг бид мэднэ. Тэгвэл та хэн нэгэнтэй бэлгийн харилцаанд орж байгаа л бол тэр хүний бэлгийн хамтрагч нартай бүгдтэй нь хавьтаж байна гэсэн үг²⁹.

Гэрлэлтийн бүртгэлээс хувь хүний хэдэн удаа гэрлэсэн талаарх түүхийг мэдэж болдог бол хамтын амьдралын түүхийг нарийн мэдэх боломжгүй. Тиймд өмнө нь хамтран амьдрагчтай байсан хүний хувьд ирээдүйн эхнэр/нөхрөө өөрөөс нь өмнө хамтран амьдрагчтай байсан эсэх, өөрт нь тууштай үнэнч байх эсэхэд итгэлгүй байдаг. Мөн эхнэрээ/нөхрөө учирч явсан бусад хүмүүстэйгээ харьцуулах зэргээр сэтгэл зүйн хувьд насан туршийн холбоос, үр дагаврыг тээсээр явдаг. Цаашилбал тохиолдлын болон хэсэг хугацааны бэлгийн харилцаатай холбоотой түр зуурынх биш сүнслэг далд холбоосууд хийгээд бусад ноцтой үр дагаврууд (*хүчирхийлэл/залилан/хүн амины зэрэг гэмт хэргийн золиос болох ирээдүйдээ ямар нэгэн арилшгүй хар толботой үлдэх гэх мэт*) байдаг. Энэ үнэнийг мэддэг, үүнд эмзэглэж явдаг хүмүүс янз бүрийн (*ном, сонин, сэтгүүл, гарын авлага, кино, дуу хөгжим, дэлгэцийн нэвтрүүлгүүд, сургалтууд болон цахим хуудас гэх мэт*) арга замаар олон нийтэд таниулах нөлөөллийн ажлууд нэлээд хийдэг. Тухайлбал, “Дэв”, “Аюултай харилцаа” зэрэг Монголын уран сайхны кинонуудыг дурдаж болох юм.

Дээрх бүгдээс дүгнэхэд хамтран амьдрах нь эцсийн дүндээ өөрийн хүсэл тачаалд захирагдан гэрлэлттэй холбоотой хариуцлагаас зайлсхийхийг оролдсон, замбараагүй/ёс журамгүй байдлыг нийгэмд халдварлуулж буй бэлгийн амьдралын хэв маяг болж байна. *Унасан бөхөд шалтаг мундахгүй* гэдэг шиг өөрсдийн хүслээ захирч чадахгүйн улмаас хамтран амьдрах сонголт хийж буй хүмүүст өөрсдийгөө зөвтгөх шалтгаан мундахгүй буй за.

16-р зууны үеийн Италийн алдартай уран бүтээлч³⁰ Микеланжело (1475-1564 он) *“Бидний олонхид маань тохиолддог хамгийн ноцтой аюул бол хэт өндөр зорилго тавиад түүндээ хүрч чадахгүйд биш, харин дэндүү өчүүхэн зорилго тавьчихаад түүндээ хүрдэгт байгаа юм”* гэж хэлсэн байдаг. Тиймд гэрлэх эсвэл хамтран амьдрах талаарх өөрийн үзэл бодлоо ухаалгаар тодорхойлж, амьдралдаа мөрдлөг болгох нь

²⁸ Гэр бүл анхаарлын төвд, 2016 он. No apologies: Амьдрал, хайр ба бэлгийн харьцааны тухай үнэн, гарын авлага. Монгол улс, Улаанбаатар хот. Хуудас 5, 46-59.

²⁹ Гэр бүл анхаарлын төвд, 2016 он. Хуудас 56.

³⁰ Микеланжело ди Лодовико Буонарроти Симони (1475-1564 он) буюу ихэвчлэн Микеланжело гэдэг нэрээр олонд алдаршсан Италийн сэргэн мандалтын үеийн зураач, зохиолч, уран бариллагч, барималч, яруу найрагч, зохион бүтээгч бөгөөд өрнөдийн урлаг болон инженерчлэлийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан хүн юм.

хүсээгүй, эрсдэлтэй, сөрөг үр дагавруудаас сэргийлээд зогсохгүй аз жаргалтай, сайн сайхан амьдралд чиглүүлэг болно.

Гэр бүлийн боловсрол - өнгөрсөн ба өнөө үед

Гэр бүлийг тогтвортой, зөв харилцаатай, хүний амар тайван аж төрөх, хөгжих, боловсрох суурь орчин болгон хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадварын цогцыг гэр бүлийн боловсрол гэнэ. Гэр бүлийн боловсрол бол хүний насан туршдаа эзэмших боловсрол юм.

Хэн боловч амар амгалан, сайн сайхан амьдрахыг хүсвэл түүний шалтгаан нөхцөлийг зөв сэтгэлээр буй болгож, сайтар хөдөлмөрлөж байж үр шимийг нь хүртдэг³¹.

Гэр бүлийн уламжлалт хэлбэрийг илүүд үздэг байсан өнгөрсөн үед ахмад үеийнхэн гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үнэлэмж, гэр бүлийн харилцааны уламжлалт нандин холбоог залуу хойч үеийнхэндээ уламжлуулан үлдээх, гэр бүлийн боловсролыг бүх нийтэд олгох тал дээр онцгой ач холбогдол өгдөг байсан. Дан ганц танхимын чанартай сурган хүмүүжүүлэх арга барилаас гадна утга, уран зохиол, тайз, дэлгэцийн бүтээлд тусгагдан үлдсэн байна. Жишээлбэл, “Энэ хүүхнүүд үү” Монголын уран сайхны киногоор жендэрийн тэгш бус байдлыг хөндсөнөөс гадна гэр бүлийн үнэ цэнэ, хосын сонголт, гэрлэх шийдвэрийн талаар залуучуудад танин мэдэх, сурган хүмүүжүүлэх утга санааг нэлээд товойлгон гаргасан байдаг. Энэ нь Төмөр, Дуламсүрэн хоёрын гэрлэлтээс өмнөх харилцаа, түүнчлэн Жамц даргын хотод хөөцөлдөхөөр ирсэн ажлаа бүтээхдээ Дуламсүрэнгийн гаргасан үйлдэлд дөрөөлөн хэлсэн хэдэн үг³², Дулмаагийн найз бүсгүйдээ хэлсэн үгээр³³ илэрч байгаа юм. Харин гэр бүлийн амьдралд хөнгөн хийсвэр хандаж болохгүй гэдэг үзэл санаа бидэнд дэлгэцээр дамжуулан өвлөгдөж, үзсэн хүн бүрт сурган хүмүүжүүлэх үүргээ гүйцэтгэсээр байгаагийн нэг тод жишээ нь “Москва нулимсанд дургүй” уран сайхны киноны Людмила, Катерина нарын дүр юм. Людмилагийн ажлын газрын хамтрагч, хими цэвэрлэгээний газрын ажилтан бүсгүй Полинагийн хэлсэн үгийг бас орхигдуулж болохгүй. Тэрээр “Генералийн эхнэр болохын тулд энгийн цэрэгтэй гэрлэж, хаа явсан газарт нь хамт явж, хатуу хүтүүг хамтдаа туулах хэрэгтэй байдаг юм” гэж Людмилад хэлдэг. Энд дурдсанаас гадна маш олон жишээнүүд одоо ч бидэнд өвлөгдөн, сурган хүмүүжүүлэх үүргээ гүйцэтгэсээр байгаа билээ.

Даяарчлагдаж буй өнөө үед дэлхий даяар мэдээлэл, туршлага солилцох аалзны тор мэт хэлхээ бий болсон. Хэн ч хаана ч очиж үзэл сурталаа нэвтрүүлэх, нөлөөллийн ажил хийх боломж бүрдсэнээс гадна гэрээсээ дэлхийн өнцөг булан бүрт болж буй үйл явдал, мэдээллүүдийг хүлээн авч байна. Мэдээллийн эрин зуунд хяналтгүй цацагдаж буй түмэн мэдээлэл дунд гэр бүлийн боловсролд сөргөөр нөлөөлөхүйц мэдээллүүд асар их байна. Монголчууд бидний хувьд ийм нөхцөл байдлаас хүүхэд, залуучуудаа хамгаалах, гэр бүлийн үнэт зүйлсийн талаарх үндэсний уламжлалаа өвлүүлэн үлдээх, Монгол гэр

³¹ Т.Намжил, 2015. *Монгол гэр бүл*, Хуудас 63.

³² “Хүү минь би чамайг ийм хүн гэж бодсонгүй. Нэгийг харж, нөгөөг мартдаг урваж, шарвадаг зантай хүнд үнэн голоосоо дургүй” гэж хэлсэн нь хосын харилцаанд үнэнч бус сэтгэл байж болохгүй санааг гаргажээ.

³³ “Дэлгүүрээс энгийн нэг бараа авахдаа сайн үзэж, шалгаж сонгодог бол насан туршийн ханиа бүр ч сайн шилж, сонгох хэрэгтэй. Идэрийн хувьд аяндаа олдсон амттай чихэрнээс, арай гэж олдсон хатуу ааруул илүү амттай. Тийм учраас зовж, шаналж л байг” гэсэн утгатай үг хэлдэг.

бүлийн үнэ цэнийг хадгалж, хамгаалахтай холбоотой гэр бүлийн боловсрол олгох нөлөөллийн ажлууд хэр зэрэг хийгдэж байна вэ? Энэ асуултыг нээлттэй үлдээе.

Ядуу сэтгэлгээний талаарх хатуухан үнэн ба комиссын бараа

Ядуурал ба худалдан авах чадварын боломжгүйдэл хүрээгээ тэлж байгаа газарт комиссын барааны эрэлт, нийлүүлэлт нэмэгддэг нь жам ёсны үзэгдэл билээ. Гэр бүлийн амьдралын хүрээнд энэхүү зүй тогтол мөн адил үйлчилдгийг илчилж тавих нь зүйтэй.

Хэн нэгэнтэй хамтран амьдарна гэдэг нь тухайн хүний бие махбод, сэтгэл зүй, халамж, анхаарлыг бүхий л талаар хүртэнэ гэсэн үг. Энэ нь хувцас, эд юмсыг өмсөж, эдэлж, хэрэглэснээс ялгаа юун. Тодорхой хугацаанд өмссөн, эдэлж хэрэглэсэн хувцас, хэрэглэлээ сонирхол буурахын цагт, таарч тохирохгүй болмогц комиссын бараанд өгдөг. Үүнтэй нэгэн адилаар хэн нэгэнтэй хамтран амьдарч байгаад таарч, тохирохгүй гэсэн шалтгаанаар салж, харилцаагаа таслах нь гэрлэлтийн зах зээлд комиссын бараа нийлүүлж байгаагаас ялгаагүй. Орчин үеийн залуучуудын дунд гэрлэлт, гэр бүлийн үнэт зүйлсийн талаар ойлголт мэдлэг дутмаг, үнэлэмж ядуу байгаа нь гэрлэлтийн зах зээлд комиссын барааны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, эргээд тэндээсээ эрэлт хэрэгцээгээ хангах суурь нөхцөл болж байна. Комиссын бараа нь хэн нэгэнд хэрэггүй болсон ч, өөр нэгний хэрэгцээг хангадаг нь үнэн. Түүнчлэн гэр бүлээ цуцлуулсан, бэлбэсэн хүмүүсийн хувьд санаа, сэтгэл нийлбэл дахин хайрлаж, дурлах, шинээр гэр бүл үүсгэх боломжийг олгох нь байх хэрэгтэй үзэгдэл мөн. Гэвч гэр бүлийн амьдралд хөл тавих гэж буй залуучууд, тэднийг залж чиглүүлэх эцэг эхүүдийн хувьд хамтран амьдрах сонирхлыг хүлээн зөвшөөрч, дэвэргэх нь гэрлэлтийн зах зээл дэх комиссын барааны нийлүүлэлтийг ихэсгэхээс өөр гавьяагүй.

Хэн ч, хэзээ ч хамгийн дуртай эд зүйлээ бусдад өгөхгүй. Түүнчлэн хамгийн чухал баяр ёслол, үйл явдлын үед хуучирч элэгдсэн, хувцас өмсөхийг сонгохгүй. Хуримын даашинз, хослолоо цэвэр цэмцгэрээр нь хуримын өдөртөө зориулж бэлтгэж, нандигнан хадгалдаг болохоос биш урьдчилж өмсөж, биедээ дасгаж байгаад ёслолдоо өмсөж ордоггүй шүү дээ.

Уншигч авхай та насан туршдаа комиссын хувцас өмсөхийг сонгох уу?

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Баталгаатай гэр бүлүүдийн хувьд алсын хараа, хамтын зорилготой байж гэр бүлийн үнэт зүйл, эд хөрөнгө, баялагийг хамтдаа бий болгон ирээдүйдээ итгэлтэй, сэтгэл хангалуун амьдрах орчин, нөхцөл бүрдсэн байдаг бол хамтран амьдрагчдын хувьд бүх зүйл эсрэгээрээ байна. Албан ёсоор гэрлэж буй хосууд ирээдүйд сална гэсэн бодлыг бус насан туршдаа хамтдаа амьдарна гэсэн итгэлийг өвөртлөн гэрлэдэг нь лавтай. Харин хамтран амьдрагчдын хувьд ирээдүй нь бүрхэг, салаа замын уулзварууд ихтэй. Гэсэн хэдий ч өнөөгийн залуучууд хамтран амьдрах хэлбэрийг илүүд үзсээр байгаа нь **гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үнэлэмж, гэр бүлийн харилцааны уламжлалт нандин холбоог алдагдуулж байгаа** билээ.

Гэр бүлийн орчин үеийн хэв маягууд дэлгэрсэн хөгжингүй улс орнуудтай харьцуулахад Монгол улс харьцангуй залуу хүн амтай³⁴гаас гадна ЖСАХ-ийн хэрэглээ харьцангуй дутмаг, гэрлэлтэд бэлтгэх гэр бүлийн боловсрол багатай, энэ талаар дагнан ажилладаг, зөвлөгөө өгдөг төрийн болон төрийн бус байгууллагууд цөөн байгаагаараа онцлогтой. Тиймд хүний нийгмийн хөгжлийг даган явагдаж буй өөрчлөлт шинэчлэлтүүдийг үгүйсгэх аргагүй ч шинэ бүхнийг даяарчлалын нөлөөлөл хэмээн **алгаа тосон хүлээн авч, даган дуурайх нь зохисгүй** мэт. Хэдийгээр гэр бүлийн тогтвортой байх эсэх нь хосууд хоорондын харилцаанаас шууд хамаарах хэдий ч гэрлэлт албан ёсны байх нь улам хариуцлагатай, баттай гэр бүлийг нийгэмд бий болгодог.

Хамтран амьдрах нь эцсийн дүндээ өөрийн хүсэл тачаалд захирагдан гэрлэлттэй холбоотой **хариуцлагаас зайлсхийхийг оролдсон, замбараагүй/ёс журамгүй** байдлыг нийгэмд халдварлуулж буй **бэлгийн амьдралын хэв маяг** болж байна.

Гэр бүлээс улс үндэстэн бүрдэж, ёс заншил, соёл, уламжлал маань хөгжин өвлөгдсөөр ирсэн. Гэр бүл нь **залуу хойч үе болох хүүхдүүдийг нийгэмшүүлэх**, хүн амыг нөхөн үйлдвэрлэх нийгмийн үндсэн нэгж, **хүний хөгжлийн анхдагч орчин** гэдэгтэй хэн ч маргахгүй бизээ. Гэр бүлийн үнэт зүйлүүд гэр бүлийн аз жаргалыг бий болгодог бөгөөд үүнийг хамтдаа бий болгож, хайрлан хамгаалж чадваас хүмүүс гэртээ сэтгэл хангалуун аз жаргалтай амьдарч чадна. *Эх нь булингартай бол адаг нь булингартай* гэдгийг тунгаан бодож насан туршийн амьдралдаа гэрлэлт, гэр бүлийн амьдралын талаарх ядмагхан ойлголтоороо гэрлэлтийн зах зээлд комиссын бараануудыг нийлүүлсээр байх эсэх нь та бидний сонголт.

Тиймд юуны түрүүнд бид дотоод сэтгэлдээ шинэчлэгдэж, сэтгэлгээгээ өөрчилснөөр эрүүл, үнэ цэнэтэй сонголт хийхийг уриалж байна. Эрүүл, зөв сонголт хийж, гэрлэх шийдвэр гаргахын тулд бие махбод, оюун санаа, зан чанар, үзэл бодлын хувьд **төлөвшсөн**, гэрлэлтийг даган ирэх үүрэг, хариуцлагыг хүлээхүйц **чадвартай** болсон байх нь чухал гэдгийг үр хүүхдүүддээ сургамжлан, үлгэрлэцгээе.

Монголын төрөөс хүн ам, хөгжлийн талаар баримтлах бодлогод: “Гэр бүл нь нийгмийн амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын төвд байлгана. Үндэсний өв соёл, удам угсаагаа хүндэтгэн ирсэн ёс заншлыг хүүхэд залуучуудад уламжлуулан хөгжүүлэхийг дэмжин урамшуулна” гэж зааснаа бодит ажил хэрэг болгох тал дээр ахин дахин, тасралтгүй анхаарч, энэ тал дээр бусад улс орнуудын туршлагыг судлан **гэр бүлийн боловсролыг олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх** нь зүйтэй.

Ашигласан материал:

Хэвлэмэл материал:

Б.Бор, 1988 он. *Гэрлэлт, гэр бүлийн тухай залуучуудад өгүүлэх нь*. Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар. Хуудас 6, 8, 24-26, 41-42.

³⁴ Нийт хүн амын 70 орчим хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг

Гэр бүл анхаарлын төвд, 2016 он. *No apologies: Амьдрал, хайр ба бэлгийн харьцааны тухай үнэн*, гарын авлага. Монгол улс, Улаанбаатар хот. Хуудас 5, 46-59.

Жу Хён Сам, 2014 он. *Гэрлэлтийн заавар*, орчуулгын ном. Соёмбо Принтинг ХХК.

МУ-ын Үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: “Өрх, гэр бүлийн байдал” сэдэвчилсэн судалгаа, 2011. “BCI” Хэвлэлийн компани. /4-7-р бүлэг & хуудас 30/

НХХЯ, ФСЭЗХ, НҮБХАС ба Улаанбаатар их сургууль, 2010 он. *Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал*, судалгааны тайлан, УБ хот. Соёмбо принтинг ХХК.

Т.Намжил, 2015. *Монгол гэр бүл*, Гэр бүл судлал, түүх, угсаатны зүйн судалгаа. Хоёр дахь хэвлэл. Бит пресс хэвлэлийн газар. Хуудас 36, 41, 63.

Шинжлэх ухааны академи, Философи социологи эрх зүйн хүрээлэн, 2012 он. *Монголын залуучуудын нийгмийн дүр төрх: XX-XXI зууны зааг үе*. Хуудас 89-108, 158-161.

УИХ-ын 2004 оны 21 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрөөс Хүн амын хөгжлийн талаар баримтлах баримтлах бодлого”

ҮСХ, 2014. *Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа*, 2013. Нэгдсэн үр дүн. Хуудас 135, 218-220, 253.

Анхдагч болон хоёрдогч мэдээллийн бааз:

Монгол улсын Үндэсний статистикийн хороо. Хүн ам орон сууцны тооллого 2010: *Үр дүнгийн хүснэгтүүд*

Улсын бүртгэлийн ерөнхий газар: *Гэрлэлтийн бүртгэлийн 1993-2013 оны мэдээлэл бааз*

Цахим эх сурвалж:

В.Батцэцэг, 2013 он. *Монгол гэр бүл*. Цуврал – 2. Нийтлэл.

<http://www.shuud.mn/content/read/292677.htm> хуудсанд 2013 оны 10 сарын 21-нд нийтлэгдсэн.

Г.Галбадрах, 2011 он. *Гэр бүлийн үнэт зүйлс ба хамтран амьдрагсад*, нийтлэл.

<http://www.orloo.info/writers/galbadrah/6152-2011-01-04-17-20-02>

Л.Цэдэвсүрэн, 2011 он. Гал голомт Үндэсний хөдөлгөөний тэргүүн Д.Мөнхөөтэй хийсэн ярилцлага. <http://miss.mn/2369.html>

Ш.Оюундалай, 2008 он. Өнөөдөр сонин. *Хамтран амьдрагчид гэр бүл мөн үү?* нийтлэл. <http://news.gogo.mn/r/19069> цахим хуудсанд 2008 оны 2 дугаар сарын 25-ны өдөр нийтлэгдсэн.

<http://news.gogo.mn/advice/1061/24584>

<http://galbaatarl.blogspot.com/2010/09/blog-post.html>